

БАТЛАВ: ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА:(Г.ЭНХМӨНХ)

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“АЛТАРГАНА ХАЙРХАН” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ (Т. БОЛД)

“АЛТАРГАНА ХАЙРХАН” ХХК

“ХУУРАЙ ТАЛ”-ЫН НҮҮРСНИЙ УУРХАЙГААС “ШИВЭЭ ХҮРЭН” БООМТ
ХҮРТЭЛХ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТО ЗАМ БАРИХ ТӨСӨЛ

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМАНД БАЙРЛАХ “ХУУРАЙ ТАЛ”-ЫН
НҮҮРСНИЙ УУРХАЙГААС “ШИВЭЭ ХҮРЭН” БООМТ ХҮРТЭЛХ ТУСГАЙ
ЗОРИУЛАЛТЫН АВТО ЗАМ БАРИХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
(АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5133351)

ХЯНАСАН:

.....: (.....)

БОЛОВСРУУЛСАН:

“АЛТАРГАНА ХАЙРХАН” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН: (А.МӨНГӨНХУЯГ)

ГАРЧИГ

1. Төслийн товч танилцуулга:	1
2. Төслийн товч тодорхойлолт.....	3-5
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	5
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	6
5. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	6

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

1.Хүснэгт 1. Алтаргана хайрхан (ХХК)-ийн мэдээлэл.....	1
2. Хүснэгт 2. 2026 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн нэгтгэл.....	6
3. Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	7
4. Хүснэгт 4. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	13
5. Хүснэгт 5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	14
6. Хүснэгт 6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	15
7. Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	16
8. Хүснэгт 8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
9. Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	20
10. Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

1. Зураг 1. “Алтаргана хайрхан” ХХК-ийн төслийн талбайн байршил.....	2
2. Зураг 2. “Хуурай тал”-ын нүүрсний уурхайгаас “Шивээхүрэн” боомт хүртэлх замын төслийн трасс.....	2
3. Зураг 3. Төлөвлөж буй тусгай зориулалтын авто замын байршлын зураг	3

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Төслийн нэр : Баянхонгор аймгийн Баян-өндөр сумын нутагт байрлах “Хуурай тал”-ын нүүрсний уурхайгаас “Шивээ хүрэн” боомт хүртэлх 244 километр тусгай зориулалтын авто зам барих төсөл

Төслийн зорилго: “Алтаргана хайрхан” ХХК нь орд газрыг бүрэн дүүрэн ашиглах зорилтын хүрээнд нүүрсийг олборлон эдийн засгийн эргэлтэд оруулж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль дүрмийн хүрээнд аюул осолгүй, үйлдвэрлэл явуулах замаар үнэ цэнэ, ач холбогдлыг нэмэгдүүлж, ашиглалтын зардлыг боломжит бага байлгаж, Монгол Улсын төсвийн бүрдүүлэлт, экспортын хэмжээг нэмэгдүүлж, орд газрын үр өгөөжийг бий болгож, үр ашгийг нэмэгдүүлэх тулд тусгай зориулалтын авто зам барьж ашиглахаар зорьж байгаа болно.

Төслийн үндэслэл: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших “Хуурай тал” нүүрсний уурхайн ашиглалтын MV-021878 тоот лицензийг “Алтаргана Хайрхан” ХХК эзэмшдэг. Засгийн газрын 2018 оны 379 тогтоолын хавсралтаар баталсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих ашиглах журам”-д үндэслэн Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутаг дахь “Хуурай тал”-н нүүрсний уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дахь Шивээ хүрэнгийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам барьж нүүрс тээвэрлэх шаардлагатай болсон.

Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл:


Хүснэгт 1. Алтаргана хайрхан (ХХК)-ийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:	▪ “Алтаргана хайрхан” ХХК- Хувийн хэргийн дугаар:9011628143- Регистрийн дугаар: 5133351
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас:	▪ Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Дүнжингарав, 48, 15 тоот ▪ Утас: 99096205
Компанийн хэлбэр	▪ Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Үйл ажиллагааны чиглэл	▪ Гадаад худалдаа
Харьяалал	▪ Монгол


Төслийн байршил:

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших “Хуурай тал” нүүрсний уурхайн ашиглалтын MV-021878 тоот лицензийг “Алтаргана Хайрхан” ХХК эзэмшдэг. Засгийн газрын 2018 оны 379 тогтоолын хавсралтаар баталсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих ашиглах журам”-д үндэслэн Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутаг дахь “Хуурай тал”-н нүүрсний уурхайн технологийн замаас эхлэл авч Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дахь Шивээхүрэнгийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам барьж нүүрс тээвэрлэх шаардлагатай болсон.

“Хуурай тал”-ын уурхайгаас “Шивээ хүрэн” боомт хүртэлх авто замын хооронд хийгдсэн инженерийн хайгуул судалгаан дээр үндэслэн гаргасан төслийн сонгосон замын нийт урт ойролцоогоор 244 км байна. Энэхүү төслийн трасс нь хөдөлгөөний эрчим багатай орон нутгийн чанартай ердийн хөрсөн зам бөгөөд Баян-Өндөр, Шинэжинст болон Гурвантэс сумуудын ард иргэд, малчид өвөлжөө, хаваржаа, намаржаа, зусландаа нүүж буух, малаа туух, сум аймгийн төв зэрэг суурин газар руу зорчих, эмнэлгийн туслалцаа авах, арилжаа наймаа зэрэг амьдралын өдөр тутмын хэрэгцээг хангах зэрэгт голчлон ашиглагддаг зам юм.



Зураг 1. Төслийн талбайн байршилн зураг



Зураг 2. “Хуурай тал”-ын нүүрсний уурхайгаас “Шивээхүрэн” боомт хүртэлх замын төслийн трасс

Байрзүйн судалгаа нь тодорхой үе шатуудаар явагдсан ба эхлээд төслийн замын нийт уртыг хамарсан өндөр нарийвчлал бүхий үндсэн өгөгдөл цуглуулж боловсруулах зорилгоор

хэмжилтийн ажлыг хийж, түүний дараа замын нийт зураглалыг гаргаж, өндөржилтийг тусгасан дижитал газрын зураг хийхээр байр зүйн нарийвчилсан судалгааг хийв. Замын трасс нь эхлэл цэгээс Тооройтын хөх уул хүртэл эхний 72 км нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын газар нутгаар үлдсэн 172 км орчим нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутгаар дайран өнгөрнө.

“Хуурай тал”-ын уурхайн нүүрс ачиж буулгах талбайгаас эхэлж Цувлуурын харын нурууны хойд талаар Эхийн голыг хөндлөн гаран Толь булгийн шалыг хөндлөн гаран Хуцын хар уулын хойд талаар Тооройтын хөх уулын урдуур гарч Баянхонгор-Өмнөговь аймгийн хил дагуулан Үхэр улаан уулын хойгуур гарч Бажууны аараг нурууны хойгуур Тостын нурууны байгалийн нөөц газар болон улсын хилийн онцгой бүсийн дундуур Хөхөлзөхийн говиор явж хойш чиглэн “Өсөх Зоос ХХК нь уурхайн замтай холбогдож “Ар Ди Си Си” ХХК-ийн Нарийн сухайт-Шивээхүрэн чиглэлийн цемент бетон замын төгсгөл хэсэгт нийлнэ.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Алтаргана хайрхан” ХХК болон “Терра Майнинг” ХХК Баянхонгор аймаг БаянӨндөр сумын нутаг дэвсгэрт орших MV-021878, MV-021480 тоотууд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хуурай тал” нүүрсний ордыг эзэмшдэг бөгөөд уг ордын геологийн тогтоосон нөөц 263,125 мян тонн ба цаашид нөөц нь өсөн нэмэгдэх бололцоотой эхний жилүүдэд 5,742-8,358 мян тонн, авто зам баригдсанаар 13,933 мян орчим тонн нүүрс олборлох хүчин чадалтай бөгөөд бүтээгдэхүүнээ БНХАУ-ын зах зээлд нийлүүлэх зорилгоор тус уурхайгаас Шивээ хүрэн боомт хүртэл 244.4 км авто замыг шинээр барихаар төлөвлөсөн.

Монгол улсын Зам, тээвэр хөгжлийн яамны 2023 оны 03-дугаар сарын 16-ны өдрийн А/64 тоот тушаалаар “Тусгай зориулалтын 244 километр авто замын замын чиглэл”-ийг баталсан байна.

Уг төслийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн №379 дугаар бүхий “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам” нөхцөлөөр хэрэгжинэ.



Зураг 3. Төлөвлөж буй тусгай зориулалтын авто замын байршлын зураг

Төслийн ач холбогдол: Тухайн бүс нутгийн байршлаас хамаарч хүн амын нутагшил бага, дэд бүтэц гэх зүйл байхгүйгээс хөгжил харьцангуй сул байгаа нь тодорхой байна. “Хуурай тал” -Шивээ хүрэн боомт чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьснаар Монгол улсын авто тээврийн харилцааг хөгжүүлэх, урд хөрш улс БНХАУ-тай хийх худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд авто тээврийн нөхцөл, хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулж, зорчигч болон ачаа тээвэрлэлтийн хугацааг богиносгох, олон улсын транзит тээврийн нэвтрүүлэн өнгөрүүлэх чадварыг дээшлүүлэх болно. Урт хугацааны үр дүн дараах үзүүлэлтүүдээр илэрхийлэгдэнэ.

- Уул уурхайн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах
- Ядуурал буурах
- Хилийн бүсэд дэд бүтэц сайжирч эдийн засгийн чадавхад сайнаар нөлөөлөх
- Аялал жуулчлал хөгжих
- Зам ашиглалтын бүтээмж нэмэгдэх, аваар осол буурах
- Байгаль орчин, хөрс, усны бохирдол багасах, агаарын чанар сайжрах, дуу чимээ багасах
- Ажлын байр нэмэгдэх
- Зам дагууд үйлчилгээний төвүүд баригдах г.м болно.

Уг төслийн зорилго нь одоогийн байдлаар нүүрс тээврийн зориулалттай боловч “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-д заасны дагуу улсын мэдэлд бүрэн шилжих юм. Уг төслийн зам баригдсанаар Гурвантэс, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан зэрэг бүс нутгийн хөгжилд нөлөөлөх боловч цаашид уг замыг үргэлжлүүлэн барьснаар Баянхонгор аймгийн нийт иргэд худалдаа наймаа эрхлэх тэнхлэгийн гол замын хэсэг болж Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, нутгийн ард иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлэхэд түлхэц болсон чухал ач холбогдолтой юм.

Газарзүйн мужлал: Төслийн талбай нь физик газарзүйн мужлалаар Говийн их мужийн талархаг тойрогт хамаарах ба Байгалийн бүс бүслүүрээр Цөлийн бүсийн Жинхэнэ цөлийн бүслүүрт хамрагдаж байна. Нутаг дэвсгэрийн ерөнхий шинж нь нам уулс, жижиг толгод бүхий гүвээрхэг, долгиорхог өргөн тал хөндийн ерөнхий шинжийг хадгална.

Уур амьсгал: Уур амьсгалын мужлалын хувьд ерөнхийдөө гандуу дулаан зун, хүйтэн өвөлтэй, өвөл зуны температурын ялгаа ихтэй, хур тунадасны хувьд бага, татруу уур амьсгалтай. Зуны улиралд халуун хуурай, өвлийн улиралд дулаан, хавар болон намрын улиралд шороон болон цасан шуургатай өдөр олон тохиолдоно. Гурвантэс сумын нутагт нарны нийлбэр цацрагийн жилийн дундаж 1500 кВт ц/м^2 -аас их, нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа жилд дунджаар 3400 цагаас их, сард 283 цагаас их, хоногт 11.8 цагаас их байдаг байна. Судалгаанд хамрагдаж буй газар нутгаар агаарын температурын олон жилийн дундаж 7.4°C болно. Жилд дунджаар нэн халуун буюу агаарын температур 30°C -ээс дээш өдрийн тоо 42 өдөр ажиглагдах. Хөрсний өнгөн давхаргын жилийн дундаж температур 8.8°C байдаг ба зөвхөн өвлийн саруудад тэг градусаас доошилдог.

Агаарын чанар: Өмнөговь аймаг нь хур тунадас бага, хуурай уур амьсгалтай нутаг бөгөөд сүүлийн жилүүдэд тус аймагт уул уурхайн салбар эрчимтэй хөгжихийн хирээр тоосжилт ихээр бий болж байгаа бөгөөд энэ нь уурхайн үйл ажиллагаа, тээвэрлэлтийн замуудтай шууд холбоотой гэж үздэг. Мөн сүүлийн жилүүдэд аймгийн нийт нутгаар хур бороо хомс, өвс ургамлын гарц муу байсан нь хөрс ихээр хуурайшиж тоос босох нэг нөхцөл болж байна.

Гадаргын ус: Ус зүйн мужлалаар Төв Азийн гадагш урсацгүй ай савын түр урсгал бүхий гол горхины мужид хамаарах ба гадаргын усны сүлжээ муу хөгжсөн, байнгын урсацтай гол горхи байхгүйгээс ус зүйн хувьд төдийлөн сайн судлагдаагүй. Монгол орны усны сав газраар Галба-Өөш Долоодын говь гэсэн ай савд хамаарагдана. Энэ бүс нутгийн олон жилийн дундаж урсац буюу модуль нь км^2 -д $0.5\text{--}0.1 \text{ л/с}$. Гадаргын урсац 5 мм, газар нутгийн нийт чийгшил 50-100 мм, голын сүлжээний нягтшил $0.01\text{--}0.05 \text{ км/км}^2$, гол мөрний нийлбэр урсац $0.5\text{--}1 \text{ л/с-км}^2$, усны гадаргаас уурших ууршилт 5-9 дугаар сард 900-1100 мм байна.

Газрын доорх ус: Өмнийн говийн тал болон хагас цөлөрхөг хуурай уур амьсгалтай геологийн нийлмэл тогтоцтой, ан цав багатай дүүрэг нь газар доорх ус бүрэлдэх хангалттай нөхцөл болж чаддаггүй тул газар доорх усны олон тооны жижиг бассейн, линз, давхаргууд үүсгэдэг бөгөөд давсархаг эсвэл давст устай байдаг. Төслийн талбай орчмын газрын доорх усны ашиглаж болох боломжит нөөцийн зургаас харахад бага нөөц баялагтай ($0.03\text{--}0.3 \text{ л/с}$) нүх сүв, ан цавын чөлөөт болон дарагдмал гадаргад ус тархсан ба газрын доорх усны нөхөн сэргээгдэх нөөц нь $< 5 \text{ мм/жил/км}^2$ бага байна.

Хөрс: Хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн их мужийн Говийн мужийн өргөргийн бүсшилийн цөлийн бор саарал хөрсний Галбын говийн тойрогт хамрагдана. Нам уулс, толгодын хэсгээр дутуу хөгжилтэй сайр чулуурхаг цөлийн бор саарал (гөлтгөнөгүй), тал хөндий, нам хотос хэсгээр цөлийн бор саарал, цөлийн мараалаг бор саарал, уугуул хэлбэрийн мараа хөрс, элсэн хөрс голлон тархана.

Ургамал: Ургамал-газарзүйн мужлалаар Тал талархуу газрын Төв Азийн бүсийн Галбын говийн (цөлийн) тойрогт хамаарагдах бөгөөд бүхэлдээ жинхэнэ цөлийн хэв шинжийг илэрхийлэгч сөөг болон хагас сөөгөнцөр ургамал зонхилон тархсан.

Амьтан: Амьтны аймгийн газарзүйн мужлалын хувьд Умард говийн болон Алтайн өвөр говийн тойрогт хамаарах (А.Г.Банников 1954) бөгөөд говь цөлийн амьтад тэргүүлж мэрэгчдээс чичүүл, савагдаахай, загийн шар чичүүл, бор зусаг, туурайтнаас хар сүүлт, хулан, янгир, аргаль, махчин амьтдаас чоно, үнэг зонхилно. Цөлийн экосистем тул амьдрах орчны элдэв хэв шинж цөөн илрэх бөгөөд бүхэлдээ нэг хэвийн амьдрах орчинтой.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Алтаргана хайрхан” ХХК-ийн Баянхонгор аймгийн Баян-өндөр суманд байрлах “Хуурай тал”-ын нүүрсний уурхайгаас “Шивээ хүрэн” боомт хүртэлх 244 километр тусгай зориулалтын авто зам барих төслийн ТЭЗҮ тайлан болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн төлөв байдлын үнэлгээний тайланг үндэслэн БОАЖЯ-ны шинжээчийн 2024 оны 05 -р сарын 12 -ний өдөр гаргасан 2024/ӨМ-164 тоот байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг ерөнхий шинжээч 2024 оны 05 -р сарын 13-ний өдрийн 12/5485 тоот албан бичгээр баталгаажуулсан байна. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал, газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр гаргаж тусгасан. Мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээ өгсөн дүнгүүдийг тусгасан болно.

Төслийн зүгээс байгаль орчны бүрдлүүдэд үзүүлэх гол нөлөөлөл нь зам тавих ажлын түүхий эд материал тээвэрлэх, түр хадгалах, шороо чулууны карьер гаргах, карьераас тээвэрлэлт хийх, замын тэгшилгээ хийх, замын хучилтуудыг тавих, асфальт бетон зуурах зэрэг ажил, зам ашиглалтад орсны дараа уг замаар тээвэрлэлт хийж байгаа машины шатахууны дутуу шаталтаас агаарт хорт хий тархах, хүнд даацын машин техникийн эрчим ихэссэнээр амьтад үргэж дайжих, зам тавьснаар нутагт бэлчээрлэж нутагладаг амьтдын тархац нутгийг хязгаарлах зэрэг гол нөлөөлөл үзүүлэхээр байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. “Алтаргана хайрхан” ХХК нь орд газрыг бүрэн дүүрэн ашиглах зорилтын хүрээнд нүүрсийг олборлон эдийн засгийн эргэлтэд оруулж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль дүрмийн хүрээнд аюул осолгүй, үйлдвэрлэл явуулах замаар үнэ цэнэ, ач холбогдлыг нэмэгдүүлж, ашиглалтын зардлыг боломжит бага байлгаж, Монгол Улсын төсвийн бүрдүүлэлт, экспортын хэмжээг нэмэгдүүлж, орд газрын үр өгөөжийг бий болгож, үр ашгийг нэмэгдүүлэх тулд тусгай зориулалтын авто зам барьж ашиглахаар зорьж байгаа болно.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

“Алтаргана хайрхан” ХХК-ийн Баянхонгор аймгийн Баян-Өндөр суманд байрлах “Хуурай тал”-ын нүүрсний уурхайгаас “Шивээ хүрэн” боомт хүртэлх тусгай зориулалтын авто зам

барих төслийн 2026 оны БОМТ-г БОАЖЯ-ийн сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ийг баримтлан боловсруулсан болно.

Төслийн байршил: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших “Хуурай тал” нүүрсний уурхайн ашиглалтын MV-021878 тоот лицензийг “Алтаргана Хайрхан” ХХК эзэмшдэг. Тус уурхайгаа Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутаг дахь Нарийн сухайт-Шивээхүрэн чиглэлийн цемент бетон замын төгсгөл хүртэл

5. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Алтаргана хайрхан” ХХК нь 2026 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд нийт 361,190,000 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө. Агаарын чанар, газрын гадарга, хөрс, гадаргын болон газрын доорх ус, ургамал, амьтан, хог хаягдлал, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг Байгаль Орчны Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсвийн тооцоог Хүснэгт 2–д үзүүллээ. Боловсруулсан БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тус тус тодорхойлон тусгасан. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтын дагуу хийж гүйцэтгэв.

Хүснэгт 2. 2026 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн нэгтгэл

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2026 оны төсөв
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	7,500,000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	304,024,000
3	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15,000,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	6,700,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,366,000
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	24,500,000
8	Нөлөөллийн бүсийн оршин суугчидад тайлагнах төлөвлөгөө	-
Нийт дүн		361,190,000

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1	Төслийг хэрэгжүүлснээр агаарт тоосжилт, тээврийн хэрэгслийн утаа зэрэг сөрөг нөлөөлөл үүсэх	Замын бүтээн байгуулалтын үед тоосжилт их үүсэх эх үүсвэрүүдийг тогтмол усалгаа хийх, чийгшүүлэх арга хэмжээ авч байх	Төслийн талбайд	Тогтмол		Үйл ажиллагааны зардал		2026 он	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 - Дизель хөдөлгүүртэй автомашин - Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 - Бензин хөдөлгүүртэй автомашин, утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009
2		Дагтаршаагүй замаар явах үедээ машин техникийн хурдыг хязгаарлах	Авто замын трассын дагуу	Тогтмол				2026 он	
3	Зам тавих үед түүний ойр орчмоор олон машин явж олон салаа зам гаргуулахгүйн тулд нэгдсэн нэг замаар явах нөхцөлийг хангах	Тогтоосон маршрутын дагуу түр зам хэрэглэх, тэмдэг тэмдэгжүүлэлтийг хийх	Авто замын трассын дагуу	Ш	-	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
4	Зам барилга, карьер олборлолт ажилд хэрэглэж буй тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн шуугиан зөвшөөрөгдөх түвшнээс ихсэх	Төслийн хүрээнд ажиллах машин техникийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, зориулалтын газар засвар үйлчилгээг тогтмол хийх	Шуугиан ихтэй техник, тоног төхөөрөмжүүд, түүнтэй харьцаж ажилладаг ажиллагсад	Тогтмол		Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
5		Шуугиан ихтэй тоног төхөөрөмжид ажиллаж буй хүмүүст хамгаалах хэрэгсэл олгож хэрэглүүлэх		Ш	-	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
Дүн									

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
6	Зам барих, ашиглах үед гадаргын болон гүний усны эх үүсвэр бохирдох, хомсдох	Зам барилгын ажилд орон нутгийн малчдын худгийн усны эх үүсвэрийг ашиглахгүй байх, гүний худаг гаргаж, орон нутгаас ус ашиглах зөвшөөрлийг авах	Төслийн талбай	ширхэг	5	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	Усны тухай хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
7		Усны эх үүсвэр, нөөц бүхий газруудыг үйл ажиллагааны ямар нэг нөлөөлөлд өртөхөөс зайлсхийх, төлөвлөхгүй байх, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийн шатанд онцгой анхаарах, ажиглах хяналт хийх	Авто замын трассын дагуу	тогтмол		Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
8		Авто замын барилгын ажлын төгсгөлд ажилчдын түр нүхэн жорлонг зохих стандартын ариутгаж, устгаж, булах	Төслийн талбайд			Үйл ажиллагааны зардал		2026 он	
9		Ус хэмнэх технологи хэрэгжүүлэх, борооны ус хуримтлуулан дахин ашиглах	Төслийн талбайд		Үйл ажиллагааны хүрээнд			2026 он	
10		Зам барилгын ажлын явцад сайр, жалга, судгийн ус хурах талбайд нефтийн бүтээгдэхүүний бохирдол үүсгэхээс зайлсхийж, нэгдсэн зогсоол байгуулах	Кемпийн орчимд	ш	3	Үйл ажиллагааны зардал		2026 он	
Дүн									

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
11	Зам барилгын ажлын улмаас хөрс, газрын гадарга эвдрэх	Хөрсний элэгдэл эвдрэл үүсэхээс сэргийлэх зорилгоор барилгын үйл ажиллагаа, тоног төхөөрөмж тээвэрлэлтээс өмнө тээвэрлэлт хийх замын маршрут, тогтсон маршрутын дагуу явуулах ба авто замын засвар үйлчилгээг тогтмолжуулах. Урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр олон салаа зам гаргах, замгүй газраар тээврийн хэрэгсэл зорчихыг хориглох	Төслийн талбайд			Үйл ажиллагааны хүрээнд		Авто замын бүтээн байгуулалт дуустал	Газрын тухай хуулийн 5-р бүлэг-Түгээмэл ашигт малтмалын тухай хууль -Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 9, 12-р зүйл
12		Зам болон хөрс газрын хэвлийг эвдрэлд оруулахгүй байх бүх талын арга хэмжээг авах, үерийн хамгаалалтын далан, суваг шуудуу байгуулах /нийт 129 ш хоолой төлөвлөсөн/	Авто замын трассын дагуу	Ш	129	Үйл ажиллагааны зардлаар		Авто замын бүтээн байгуулалт дуустал	MNS 5917: 2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлагаMNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээMNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
									суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ”
13	Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, ахуйн хог хаягдлаар хөрс бохирдох	Хөрсний бохирдлоос хамгаалах зорилгоор бүх ажилчдад техникийн болон ахуйн хэрэглээний аюултай материал (химийн бодис, шатамхай хий, шатах, тослох материал)-тай харьцах асуудлаар цогц сургалт, зааварчилгаа явуулах	Ажилчдад	тогтмол		Үйл ажиллагааны хүрээнд		Төсөл дуустал	
14		Зам, барилгын ажлын талбай дахь хатуу хог хаягдлыг цуглуулж, зохих журмын дагуу зайлуулж байх	Төслийн талбай		Сар бүр	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
15		Зориулалтын хог хаях цэгээс бусад газар хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдлыг ангилан ялгах арга хэмжээг хэвшүүлэх талаар ажилчдад заавар зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах, самбар пайз байрлуулах	Төслийн талбай	Тогтмол	5	500.0	2500.0	2026 он	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
16	Байгалийн элс, хайрга, чулуу олборлож, түүгээр авто замын далан байгуулж, газрын гадаргад хотгор гүдгэрийн хэлбэр үүсгэнэ	Карьерын хананд хэвгийжүүлэлт хийж гулсалт нуралтгүй болгон, урсгал усны үйл ажиллагааны нөлөөллөөр элэгдэл эвдрэл үүсэхээргүй болгон тогтвортой байдлыг хангах байдлаар техникийн нөхөн сэргээлт хийх	Төслийн талбай	Удаа	-	Үйл ажиллагааны хүрээнд		Карьер бүрийн ашиглалтын төгсгөлд	
17	Хөрсний үржил шимт давхаргыг хуулах хөрсний үржил шимт байдал алдагдах	Зам барилгын ажил эхлэхийн өмнө өнгөн хөрсийг “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт MNS 5916:2008”-д заасны дагуу хөрсний ялзмагт давхаргаас хамаарч хөрсийг хуулж, тусад нь хадгалан, техникийн болон биологийн нөхөн сэргээлтэд ашиглах	Хөрсөн бүрхэвч	Удаа	-	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
Дүн							2,500,000		
Ургамал, биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
18	Зам ашиглалт, тоосжилтоос шалтгаалан замын дагуух ургамал нөмрөг доройтох	Орчны ургамлан бүрхэвч устах, талхлагдах, олон салаа зам гарахаас сэргийлэх, чөлөөт зорчилтыг хязгаарлах арга хэмжээ авах	Төслийн талбай	тогтмол		Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	Нөхөн сэргээлтийн аргачлал Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай MNS 4585:2016
19		Замын хажуу хэсгийн ургамлыг аль болох сүйтгэхгүй байх. Машин техник тоног төхөөрөмж	Төслийн талбай	-	-	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
		зөвхөн төлөвлөсөн замын дагуу явах							
20		Түр замд өртөх талбайн өнгөн хөрстэй хэсгийн өнгөн хөрсийг авч нөхөн сэргээлтийн хөтөлбөр, ургамалжуулалтын үйл ажиллагаанд ашиглах	Төслийн талбай	-	-	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
21	Ургамлан бүрхэвч талхлагдаж болзошгүй	Замын барилгын ажилд ашигласан карьер, ажлын талбарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх	Замын барилгын ажилд ашигласан карьер, ажлын талбарт	-	-	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн хэсэгт оруулсан		2026 он	
22		Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарих	Төслийн талбай	1 га	-	5,000.000		2026 он	
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
23	Авто зам тавигдсанаар амьтдын амьдрах орчин хязгаарлагдах, хуваагдах байдалд орох, замаар зорчих тээврийн хэрэгсэлд мөргүүлэх	Замын трассын дагуу болон түүний зэргэлдээх амьдрах орчин, амьтдын зүйлийн бүрдэл, тоо толгой, шилжилт хөдөлгөөн, мөн авто замын ачаалал, гэрийн малын байршил зэргийг үндэслэн тохиромжтой цэгүүдэд Зэрлэг амьтад болон гэрийн малд зориулсан сонгогдсон гарцыг байгуулах шаардлагатай	Зэрлэг амьтны гарцыг 9 цэгт байгуулна	ш	-	Үйл ажилгааны хүрээнд		2026 он	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
24		Машин техникийн хурдыг хязгаарлаж, талбайд нүүдэллэн орж ирж болзошгүй амьтдыг дайрч, мөргөхөөс болгоомжлох, нүүдлийн үеэс өмнө тээврийн жолооч нарт зөвлөмж өгөх	Тээврийн жолоочид	удаа	3	Үйл ажилгааны хүрээнд		2026 он	
25		Ан амьтдын ундаалдаг байнгын болон түр зуурын устай булаг, ил задгай ус, устай тойрмыг хамгаалах хөндөхгүй байх	Төслийн талбай		Үйл ажилгааны хүрээнд		2026 он		
26		Төсөл хэрэгжих сумдад биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Үүнд: жил бүрийн өвөл, хаврын улиралд төсөл хэрэгжих орон нутагт тохиолдох зэрлэг амьтдад өвс тэжээл, хужир мараа, мөс авч өгч, нутгийн удирдлага болон амьтныг өсгөн үржүүлэх мэргэжлийн эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах	Төсөл хэрэгжих сумд	удаа	1	Үйл ажилгааны хүрээнд		2026 он	
27	Жижиг амьтдын үүр оромж хөндөгдөх	Газар шорооны ажлын үед жижиг амьтны үүр оромж хөндөгдөж эвдэгдсэн цэгүүдэд нөхөн сэргээлт хийх	Төслийн талбай	-	Үйл ажилгааны хүрээнд		2026 он		
28	Мал амьтад ухсан нүхэнд унаж бэртэх	Чулуу, элс хайрганы карьерын нуралт гулсалт	Төслийн талбай	-	Үйл ажилгааны хүрээнд		2026 он		

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
		үүсэж болзошгүй эгц налуу хэсгүүдэд хүн, мал амьтан орохоос хамгаалах хамгаалалтын хайс, тор хийх;							
Дүн							-		
Бусад									
29	Цахилгаан эрчим хүчний хэрэглээ	Сэргээгдэх эрчим хүчийг илүүтэй сонгож хэрэглэх	Төслийн талбай	Иж бүрэн		Үйл ажилгааны хүрээнд		2026 он	Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
30		Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгож хэрэглэх	Төслийн талбай	Иж бүрэн		Үйл ажилгааны хүрээнд		2026 он	
Нийт дүн							7,500,000		

2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйл: Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувь нь ногоон байгууламжтай байна.

Хүснэгт 4. Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг /мян/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ногоон байгууламж бий болгох	Мод тарих	Бүйлс, харгана, сухай	Ширхэг	100	Үйл ажиллагааны зардал		2026 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 4585:2016 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр
2	ТТАМ-ын шороон ордуудаас ашигласан талбай болон төслийн үйл	Карьерийг тухайн газрын ландшафтай нь уялдуулан түрж тэгшлэх,	Захирамжаар олгогдсон Түгээмэл тархацтай ашигт	га	-	304,024,000		2026 он	

	ажиллагааны явцад эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх	хэлбэржүүлэх налуулах	малтмалын талбай, бусад эвдэрсэн газар					тарих, арчлах MNS 6260 : 2020 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал MNS5916:2008
Нийт дүн						304,024,000		

3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төсөл хэрэгжих орчны нөлөөллийн бүсэд газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй байгаа бөгөөд нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэхгүй гэж байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон.

4.Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх;
- Төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-ын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээн ажиллана.

Хүснэгт 5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх арга хэмжээ авна.	Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх арга хэмжээ авна.	Төсөл хэрэгжүүлэх нийт талбайн хэмжээнд	Тухайн үед нь шийдэх	Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга

5. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг /мян/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл	Ажлын идэвхтэй талбайг тойруулан хангалттай/зохистой гэрэлтүүлж, гэрэл цацруулагч саад (боломжтой бол, түр хашаа барих) тавих	Төслийн талбайн эрүүл ахуйн хамгаалалт ын бүс	Иж бүрэн	1	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	MNS 4990: 2015 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”;MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”;MNS 5390:2004, “ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”; MNS 6768:2019MNS 6767: 2019; MNS 6769:2019; MNS6770:2019; MNS 6654:2017 MNS 5107:2001“Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”
2		Гал гарах зэрэг онцгой нөхцөлд хариу ажиллах бэлэн байдал (журам мөрдөх, ажилчдыг сургах, тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамж)	Төслийн талбай	Тогтмол	-	2,500.000		2026 он	
3		Төслийн тухай мэдээллийн самбар, ажил эхлэх, дуусах хугацаа, Гүйцэтгэгчийн нэр, холбоо барих хаяг, талбайн удирдах ажилтан, ачааны машинуудын явах зам, дэд төслийн зохион байгуулалт зэргийг мэдээлнэ	Төслийн талбай	Иж бүрэн	1	1,000.000		2026 он	
4		Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг графикийн дагуу хийдэг, бүртгэл	Төслийн талбайн эрүүл ахуйн хамгаалалт ын бүс	Тогтмол	1	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	

		хөтөлдөг, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөх, хяналтын ажилтныг томилон ажлын байрны тодорхойлолтод ажил үүргийн хуваарийг нарийн тусгах						
5	Үйл ажиллагааны явцад ажиллагсад осол, аварга өртөж болзошгүй	Ажилчид, тоног төхөөрөмжийг авчрахаас өмнө ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, аюулгүй байдлын дүрмийг хатуу мөрдөх талаар танилцуулна	Бүх ажилчид	тогтмол	1	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он
6		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм журмуудыг бүрэн боловсруулж мөрдүүлэх, курс, сургалтын болон зааварчилгаа өгөх ажил зохион байгуулах	Бүх ажилчид	Иж бүрэн	Жилд 2 удаа	500.0	1,000.000	2026 он
7		Осол эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах	Төслийн талбай	тогтмол	Жил бүр	2,500.000		2026 он

8		Ажилчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулах	Бүх ажилчид	Удаа	1	Гэрээт ажлын дүнгээр	2026 он	
9		Ажилчдын түр баазыг үер усны аюулаас сэргийлж үерийн далан байгуулах	Ажилчдын түр баазад	Удаа	1	5,000.000	2026 он	
10	Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аваарт өртөх	Гал түймрээс хамгаалах багаж хэрэгслийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах	Төслийн талбай	тогтмол	1	1,000.000	2026 он	Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он; Гамшгаас хамгаалах тухай хууль, /шинэчилсэн найруулга/ 2017 он; MNS 4244:1994 “Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага” MNS 5566: 2020 Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага норм
11		Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах	Төслийн талбай	Удаа	Жилд 1	Үйл ажиллагааны хүрээнд	2026 он	
12		Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болох лоом, хүрз, сүх, хөрөө, хувин, хоолой, багор дэгээ, жоотуу, тармуур, хөөс, хорны суурь, тэмдэг тэмдэглээ, сарай, элсний хайрцаг, шланг зэргийг бэлэн байлгах.	Төслийн талбай	тогтмол		Үйл ажиллагааны хүрээнд	2026 он	
13		Газрын эргүүл гаргаж тодорхой маршрут, тогтоосон	Төслийн талбай	1 удаагийн маршрутын зай мотоцикл, авто		2,000.000	2026 он	

		цагаар явуулын ажиглалт хийх		машин 50-100 км түймрийн аюултай хугацаанд			
Нийт дүн					15,000.000		

6. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан мониторингийн цэгээс хөрс, ус, агаарын дээжийг тогтмол хугацаанд авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэж. Байгаль орчны хяналт шинжилгээний тайлангийн үр дүнг жил бүрийн БОМТ-ний биелэлтийн тайланд тусгаж төсөл хэрэгжих сумдын багийн удирдлага болон нөлөөллийн бүсийн иргэдэд нээлттэй мэдээлж байх үүрэг хүлээж ажиллана.

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал	Нийт зардал, төг /мян/	Баримтлах стандарт, арга аргачлал
	1	2	3	4	6	7	9
Агаарын чанар							
1	CO2, NO2, SO2 Тоос нийт (PM10, PM2.5)	Замын трассын дагуух хяналтын 10 цэгт	Жилд 2 удаа	10 цэгт	74000	1,480.000	Агаарын тухай хууль, Агаар мандлын сорьц авах ерөнхий шаардлага УСТ 3384-82 Агаарын чанар MNS 4585:2016 MNS 5014:2009
2	Дуу шуугиан хэмжээ	Идэвхтэй ажил явагдаж буй 5 цэгт	Жилд 2 удаа	5 цэгт	38000	380.000	
Хөрс							
3	Хөрсний агрохими ерөнхий үзүүлэлт		Жилд 2 удаа	10 цэгт	25000	500.000	MNS 3298-1991 MNS 3310: 1991 MNS ISO 11269-1:2002 MNS 5850: 2019 MNS 3297:2019
4	Хөрсний хүнд металлууд		Жилд 2 удаа	10 цэгт	38000	760.000	
5	Хөрсний микробиологийн шинжилгээ		Дулааны улиралд 2 удаа	2 цэгт	25000	100.000	
Усны чанар							
6	Органик бохирдол	Унд ахуйн уснаас 1 цэг (унд ахуйн хэрэглэж буй уст	Жилд 2 удаа	1 цэгт	25000	50000	MNS 0900:2018
7	Усны химийн найрлага, хүнд металлын		Жилд 2 удаа	1 цэгт	48000	96000	MNS 0900:2018

	агууламж, бактериологи	цэг, булаг, худаг гэх мэт)					
Амьтны аймаг							
8	Амьтны мониторинг	Ан амьтны шилжилт хөдөлгөөн идэвхтэй явагддаг цэгүүдэд	Жилд 1 удаа	Төслийн талбайн хэмжээнд мэргэжлийн зөвлөх ажиллуулж мониторингийн судалгаа хийнэ	Гэрээний үнийн дүнгээр	Амьтны тухай хууль	
Ургамлын мониторинг							
9	Ургамлын мониторинг	Замын трассын дагуу	Жилд 1 удаа	Төслийн талбайн хэмжээнд мэргэжлийн зөвлөх ажиллуулж ургамлын бичиглэл хийнэ.	Гэрээний үнийн дүнгээр		
	Нийт дүн				3,366.000		

7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1		2	3	4	5	6	7	8
1	Ахуйн	Хог хаягдлын менежментийг зохистой төлөвлөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх буюу 5Э зарчмыг баримтлан ажиллах	Төслийн талбай	тогтмол	2	500.0	1,000.0	2026 он	Хог хаягдлын тухай хууль; БОАЖ-ын сайдын А/433 тушаал “Ариун цэврийн тухай” хууль; БОАЖ-ын сайдын 2017 оны А/349 тушаал Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; БОАЖ-ын сайдын 2017 оны А/368 тушаал Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал; БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаал Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах; БОАЖ-ын сайдын 2018 оны А/443
2		Зам талбайн хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах	Төслийн талбай, гадна орчин	удаа	12	Дотоод зохион байгуулалтаар		2026 он	
3		Ажлын талбайн хэсгүүд ба түр сууринуудад хатуу хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын зөөврийн савуудтай байх	Төслийн талбай	ш	-	5,000.0	5,000.0	2026 он	
4		Энгийн хог хаягдлын гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулан гэрээний хэрэгжилтийг биелүүлэх	Төслийн талбай	тогтмол	-	Гэрээний дүнгээр		2026 он	
5		Хог хаягдлыг нэг цэгт цуглуулан ангилж, зориулалтын дагуу хадгалан тогтмол хугацаанд тээвэрлүүлж байх	Төслийн талбай	удаа	тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгах		2026 он	
6	Үйлдвэрийн	Барилгын ажлын явцад гарсан илүүдэл чулуу, шороо болон барилгын	Төслийн талбай	удаа	тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгах		2026 он	

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1		2	3	4	5	6	7	8
		ажилчдын суурингийн талбай, түүхий эд материалын агуулах, машин техникийн зогсоолын талбай, хог хаягдлын талбай зэргийг бүрэн цэвэрлэж, хог хаягдлыг зохих газар нь хаях							тушаал Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
7	Аюултай	Аюултай хог хаягдлыг тусгайлан бэлтгэсэн зориулалтын цэг, савт цуглуулах	Төслийн талбайн аюултай хог хаягдлын цэг	удаа	тогтмол	Үйл ажиллагааны зардлаар		2026 он	БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 тушаал Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар; БОАЖ-ын сайдын 2018 оны А/21 тушаал; MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
8		Авто машин механизмын ашигласан тос, тосолгооны материалыг битүү саванд хуримтлуулан хадгалж дахин боловсруулах үйлдвэрт тушаах	Төслийн талбай, кемп	удаа	1	Гэрээний дүнгээр		2026 он	
9		Ариутгал халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах	Хог хаягдлын цэг болон өрөө тасалгаа	удаа	2	700.000	700.000		
		Нийт дүн				6,700,000			

8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд бүхий л ажилтнуудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцоолсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцах албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			... сар	... сар	... сар		
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчны менежмент төлөвлөгөө ба түүний биелэлтийн тайланг боловсруулах, батлуулах, дүгнүүлэх	3,500.0	9 сар		11 сар	“Алтаргана хайрхан” ХХК Байгаль орчны мэргэжилтэн	
2	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 101 болон БО-ны ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	16,000.0	3-4-р улиралд			“Алтаргана хайрхан” ХХК	БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
3	Байгаль хамгаалах чиглэлээр шинийг санаачилсан ажилтанг шагнаж урамшуулах	Үйл ажиллагааны зардалд			12 сар	“Алтаргана хайрхан” ХХК	
4	Ус ашиглах зөвшөөрөл, дүгнэлт гаргуулах	5,000.000			12 сар	“Алтаргана хайрхан” ХХК	

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцоолсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцах албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			... сар	... сар	... сар		
	1	2	3	4	5	6	7
5	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны турш			“Алтаргана хайрхан” ХХК	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
6	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг төсөвлөн, санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх, 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлэх.	Үйл ажиллагааны зардалд	Шаардлагатай үед			“Алтаргана хайрхан” ХХК	
7	Байгаль орчныг хамгаалах, осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.	Үйл ажиллагааны зардалд	Үйл ажиллагааны явцад			“Алтаргана хайрхан” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн	
Нийт дүн			24,500.000				

9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх “Хуурай тал”-ын нүүрсний уурхайгаас “Шивээ хүрэн” боомт хүртэлх тусгай зориулалтын авто зам барих төсөл нь Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Өмнөговь аймгийн Гурвантэс сумдын нутагт хэрэгжих тул төслийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хамгийн их сонирхогч, оролцогч талууд нь эдгээр дүүргийн удирдлагууд, ард иргэд, оршин суугчид болно. Тиймээс сонирхогчид болон оролцогч талуудад хүргэх мэдээллийг тэдгээрийн сонирхолд нийцсэн хэлбэрээр бэлтгэж, хэлэлцүүлэх, танилцуулах арга хэмжээг зохион байгуулна.

Хүснэгт 10. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
Сумын байгаль орчны газарт	Тайлагнах, мэдээлэл хүргүүлэх	Төслийн талбайд хийсэн ус, хөрс, агаарын чанарын шинжилгээний дүн	Улирал бүр	Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны мэргэжилтэн	- Баянхонгор, Өмнөговь аймгийн БОГ-т - Төрийн захиргааны төв байгууллага
Төсөл хэрэгжүүлэгч	Уулзалт, тайлагнах	БОМТ-нд тусгагдсан ажлууд, түүний хэрэгжилтийн талаар	Улирал бүр	Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны мэргэжилтэн	- Төв оффис
Орон нутаг	Уулзалт	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлт, ирэх онд хийхээр төлөвлөсөн БОМТ-д тусгагдсан арга хэмжээ, Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх	11-12 сар			- Багийн төв
	Хуралд танилцуулах, хэлэлцүүлэх			Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны мэргэжилтэн	- Сумын төв
Төрийн захиргааны төв байгууллага	ТЖБОМТ-г хянуулах		Тухай бүрд	Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны мэргэжилтэн	- Сум, багийн төв, төслийн талбай
Нийт дүн			-			